



ДАРХАН - ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР
ОНӨААТҮГ-ын ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 108

Дархан

Ажилтан сонгон шалгаруулах журам
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, “Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт, ТУШААХ нь:

1. Байгууллагын “Ажилтан сонгон шалгаруулах журам” –ыг хавсралтаар баталсугай.
2. Дээрх журмыг мөрдөж ажиллахыг Ерөнхий инженер (Ч.Батбулган)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТБАЯР

“Дархан-Хот байгуулалт барилга захиалагчийн газар”
ОНӨААТҮГазрын даргын 2023 оны...02...дугаар
сарын...15...ны өдрийн...1108...дугаар
тушаалын хавсралт

АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГазрын сул, эзгүй орон тоог нөхөх ажилтан сонгон шалгаруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Ажилтан сонгон шалгаруулахад Монгол улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалтад оролцогчдын бүрдүүлэх материал

2.1 Ажилд орохыг хүссэн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- 2.1.1 Анкет
- 2.1.2 Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 2.1.3 Иргэний үнэмлэхний хуулбар
- 2.1.4 Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар
- 2.1.5 Зэрэг, цолыг тодорхойлсон баримт
- 2.1.6 Зураг 2% /3х4/
- 2.1.7 Бусад бичиг баримт

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг хүлээн авах

3.1 Байгууллагаас зарласан ажлын байранд заагдсан зар олон нийтэд зарласан өдрөөс ажилтан сонгон шалгаруулах ярилцлагын шалгалт хүртэл хүлээн авна.

3.2 Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1 Сонгон шалгаруулалт нь ярилцлага болон мэдлэг, ур чадвар сорилтын 2 үе шаттай байх бөгөөд ажилтан сонгон шалгаруулах ажлыг газрын дарга, ерөнхий инженер нар зохион байгуулна.

4.2 Мэдлэг, ур чадварын сорилтын асуулгыг тухайн сонгон шалгаруулах албан тушаалын дагуух мэргэжлийн албан хаагчаас санал авч боловсруулна.

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

5.1 Байгууллага нь оролцогчдын шалгаруулалтад тэнцсэн болон тэнцээгүй тухай мэдээг холбогдох утсаар болон цахим хаягаар хүргэнэ.

5.2 Сонгон шалгаруулалтад тэнцэн, өндөр оноо авч, эхний 2 байранд тэнцсэн ажил горилогчийг газрын удирдлагууд хэлэлцэн шийдвэр гаргана.

Зургаа. Бусад зүйл

6.1 Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулан холбогдох материалыг бичиг хэрэгт хүргүүлнэ.

6.2 Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 1 хоногийн дотор газрын дарга шийдвэрлэнэ.